

## САНГИЙН ЯАМ

2020.04.20

### ХЯНАЛТЫН КАМЕР, БИЧИГЧ СИСТЕМ НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалт: СЯ/202003035

Улаанбаатар хот  
2020 он

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**Сангийн яам** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Хяналтын камер, бичигч систем** нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 10 цаг 00 минутаас** өмнө худалдан авах ажиллагааны цахим сайт [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 10 цаг 30 минутад** нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх. Тооцохгүй;

Сонирхсон этгээд холбогдох мэдээллийг доорх хаягаар авч болно.

Сангийн яам, Засгийн газрын 2-р байр “Д” корпус,  
С.Данзангийн гудамж, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар,  
211 тоот, Э.Энхчимэг, 71001111,

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

  - (а) Үнийн санал;
  - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
  - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
  - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
  - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгөөр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> <li>- 2019 оны ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагатай байх ба туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээ, гэрээ дүгнэсэн акт/ ирүүлнэ. /Ижил төстэй ажилд камерын төхөөрөмж, түүний систем нийлүүлснийг тооцно/;</li> <li>- Нийлүүлэх камер болон системийн зураг, үзүүлэлт, танилцуулга ирүүлэх;</li> <li>- Санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг баримт бичгийн техникийн тодорхойлолттой харьцуулсан хүснэгт ирүүлэх;</li> <li>- Шалгарсан тохиолдолд техникийн тодорхойлолтод нийцсэн, чанартай барааг нийлүүлэх болон баталгаат хугацаанд засвар үйлчилгээг түргэн шуурхай хийж гүйцэтгэх талаар албан бичиг ирүүлэх</li> <li>- Санал болгож буй камер болон программ хангамжийн үйлдвэрлэгчээс олгодог мэргэжлийн 1 /нэг/-ээс доошгүй инженертэй байх; /Сертификат/</li> </ul>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Тендерийг худалдан авах ажиллагааны <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> хаягаар хүлээн авна.</p> <p>Огноо: <b>2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>10 цаг 00 минут</b></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Сангийн яам, Засгийн газрын 2-р байр “Д” корпус, С.Данзангийн гудамж, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар;</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: 2 давхар 211 тоот;</p> <p>Огноо: <b>2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>10 цаг 30 минут</b></p>
ТӨӨЗ 2.3	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Тендерт оролцогчийг эрх бүхий болохыг нотлохтой холбоотой баримт бичиг</li> <li>2. Тендерийн маягтууд</li> </ol>

## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### 1. Барааны тодорхойлолт:

#### Ерөнхий шаардлага

- Олон улсын стандартад нийцсэн байх;  
/ HD-SMPTE 296M (720P), SMPTE 274M(1080P), IEC 60068-2-14, IEC 60068-2-6, IEC 60068-2-27, IEC/EN 62262 IK08, IEC/EN/UL 60950-1, IS 13252/
- Тоон технологи дээр ажилладаг, боловсруулалт хийдэг байх;
- Дүрсийн ялгаралт сайтай байх;
- Бичлэгийг 24 цагаар 30 хоног хадгалах компьютер эсвэл бичигч төхөөрөмж хийдэг байх;
- Бүх камерыг 24 цагаар 30 хоног болон түүнээс дээш хугацаанд хадгалах горимтой байх
- -40 °C аас доошгүй, 50 °C-аас дээшгүй нөхцөлд ажиллах чадвартай байх;
- Хамгаалалтын, суурилуулалтын, холболтын дагалдах төхөөрөмжтэй байх:  
\Тэжээлийн блок, утас далдлагч, кабель, шилэн кабель гэх мэт\
- Камерын систем рүү нэвтэрч, нэг нэгээр нь ба хэсэг камеруудаар давхар хяналт хийх боломжтой байх;
- Камерт хандалт хийх компьютерыг IP хаягаар мөн хэрэглэгчийн нууц үгээр хязгаарлах боломжтой байх;
- Хяналтын камерууд болон бичигч системийг суурилуулах ажлыг зохион байгуулах

#### Тусгай шаардлага

##### Дотор тавигдах хяналтын камер – хөдөлгөөнгүй Дом загвар

- Сүлжээний камер
- Onvif болон SMPTE 274M(1080P), IEC/EN/UL 60950-1, IS 13252 стандартыг хангасан
- Дүрсний нягтрал: 1920x1080 ба түүнээс дээш
- 1920x1080 ба түүнээс дээш нягтрал дээр секундэд 25 – 30 кадр дамжуулах чадвартай
- Дүрсний MJPEG, H.264 формат дэмждэг, сүлжээнд өгөх ачааллыг тохируулах боломжтой (VBR/MBR) шахалтын горимтой
- Харах өнцөг 105 градусаас багагүй байх
- Дүрсийг 2 хэсэгт хуваан тус тусад нь дамжуулах боломжтой байх
- 512 MB санах ойтой
- Коридор, нарийн заал харуулахын тулд дүрсийг 0-270 градус эргүүлж тохируулах боломжтой байх
- Хяналтын тодорхойлсон цэг рүү ойртуулан татаж харуулах дижитал PTZ санамжтай байх
- HDMI гаралттай байх,
- Камер руу ftp протоколоор хандаж тохиргоо хийх боломжтой байх
- Олон хэрэглэгч зэрэг хандахад сүлжээнд өгөх ачаалал өсөхгүй байхаар Multicast хийх боломжтой байх
- Edge storage хадгалалтын функц
- Линз Fixed iris байх
- Араас тусах гэрлийг тохируулах WDR forensic capture линзтэй
- PoE буюу сүлжээний утсаар тэжээл авдаг байх

##### Гадаа тавигдах хяналтын камер – Хөдөлгөөнгүй загвар

- Сүлжээний камер
- Onvif болон HD-SMPTE 296M (720P), SMPTE 274M(1080P), IEC 60068-2-14, IEC 60068-2-6, IEC 60068-2-27, IEC/EN 62262 IK08 стандартыг хангасан
- Дүрсний нягтрал 2688x1520 ба түүнээс дээш
- 2688x1520 ба түүнээс дээш нягтрал дээр секундэд 25 – 30 кадр дамжуулах чадвартай
- Линз Fixed iris удирдлагатай
- Infrared гэрэлтүүлэгтэй

- Харах өнцөг 130 градусаас багагүй байх
- Дүрсний MJPEG, MPEG4, сүлжээнд өгөх ачааллыг тохируулах боломжтой (VBR/MBR) H.264 шахалтын горимтой
- Дүрсийг 2 хэсэгт хуваан тус тусад нь дамжуулах боломжтой байх
- Хяналтын тодорхойлсон цэг рүү ойртуулан татаж харуулах дижитал zoom санамжтай байх
- Камер руу ftp протоколоор хандаж тохиргоо хийх боломжтой байх
- Олон хэрэглэгч зэрэг хандахад сүлжээнд өгөх ачаалал өсөхгүй байхаар Multicast хийх боломжтой байх
- Edge storage хадгалалтын функц
- Өдөр болон шөнө ажиллах боломжтой (IRCUT Filter, WDR forensic capture ба хэт бага гэрлийн орчинд (0.3 люкс гэрэлтэй үед өнгөт дүрс авдаг байх)
- PoE буюу сүлжээний утсаар хамгаалалтын гэр болон хяналтын камерыг цахилгаанаар хангах чадвартай
- -30 °C аас 50 °C-т ажилладаг байх
- IP66-NEMA 4X, IK10 үзүүлэлт бүхий хамгаалалтын гадна гэртэй

### **Бичлэгийн программ**

- Хамгийн багадаа 250 хүртэлх камер дэмжиж ажилладаг байх
- Дуу бичих чадвартай байх (олон сувгаар)
- Бичлэгийг байнга болон хөдөлгөөн илэрсэн үед хийх боломжтой
- Программд аудит хийх боломжтой байх
- Клиент программ болон веб интерфэйстэй
- Клиент программ нь нэгэн зэрэг олон сервер лүү хандалт хийх чадвартай
- Хяналтын дэлгэцийг олон янзаар хуваах боломжтой
- Сүлжээнд өгөх ачааллыг тохируулах боломжтой
- Олон шатлалт бичлэг хадгалалт
- Бичлэгт тэмдэглэгээ хийдэг байх
- Бичлэгийн сервер лүү хөдөлгөөнт төхөөрөмжөөс хандалт хийх чадвартай бай
- Microsoft Active Directory дэмжиж ажилладаг байх
- Төвлөрсөн менежмент хийх боломжтой бай
- Программд камерын байршлын зураг оруулдаг байх
- Байршлын зургаас камер луу хандалт боломжтой байх
- Нууцлалын маск оруулдаг байх
- FULL Frame бичилт хийдэг байх
- Хэрэглэгчийн эрхийг хязгаарлах боломжтой байх
- Хэрэглэгч нууц үгнээс гадна давхар зөвшөөрлөөр нэвтэрдэг байх
- Билиг хадгалах төхөөрөмж
- Бүх камерыг 24 цагаар 30 хоног болон түүнээс дээш хугацаанд хадгалах горимтой байх
- DVD болон зөөврийн диск дээр архивлах боломжтой байх
- Компьютерт суурилсан байх
- Лицензийн мэдээллийг онлайн аар харах боломжтой байх
- Бичлэгийн серверт гэмтэл гарахад автоматаар нөөц сервер руу шилжиж, хяналтын систем ажиллагаа доголдохгүй байх боломжтой байх
- Программын туршилтын хувилбарыг тендерийн материалд хавсаргасан байх
- Бичлэгийг зөвхөн программын өөрийн тоглуулагчаар нээдэг байх
- Бичлэгийг засварлах боломжгүй усан тэмдгээр баталгаажуулдаг байх
- DVR –г системд нэмэх боломжтой байх
- Газрын зураг дээрээс хяналт хийх боломжтой байх
- Гар утас, таблет, компьютер зэрэг бүх төрлийн төхөөрөмжүүдээс хандах клиент программтай байх.

**2. Стандарт:** HD-SMPTE 296M (720P), SMPTE 274M(1080P), IEC 60068-2-14, IEC 60068-2-6, IEC 60068-2-27, IEC/EN 62262 IK08, IEC/EN/UL 60950-1, IS 13252

**3. Баглаа, боодол:** Тусгай нөхцөл байхгүй.

4. Бараа хүргэх газар: Сангийн яам, Засгийн газрын 2-р байр “Д” корпус, С.Данзангийн гудамж, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар;

5. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

**БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Гадаа тавигдах хяналтын камер	Хяналтын камер	7	ш	ЗГ-ы 2 дугаар байр, “Д” корпус	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 14 хоногийн дотор бүрэн суурилуулж хүлээлгэн өгсөн байна.		
Дотор тавигдах хяналтын камер	Хяналтын камер	13	ш				
Хяналтын камерын систем	Хяналтын камерын программ хангамж	1	ш				
Камерын холболтын лиценз		40	ш				
Камерын суурилуулалт	Гадна, дотор байрлах камеруудыг суурилуулах	10	ш				



Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

**Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт** танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| 1. Шалгах болон турших                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 3 жил байна.  |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах         | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.   |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>                             | 1.1. Камер болон системийг бараа хүргэх эцсийн цэгт шалгаж туршиж хүлээн авна.   |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b> | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ol style="list-style-type: none"><li>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;</li><li>2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;</li><li>3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;</li><li>4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;</li><li>5) барааны гарал үүслийн гэрчилгээ.</li></ol> <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| <b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b>                                  | <p>5.1. Баталгаат засварын тусгай шаардлага. Баталгаат засварын хугацаанд гарсан гэмтэл, доголдолыг түргэн шуурхай засварлах.</p> <p>[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]</p>  |
| <b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>  | <p>7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:</p> <p>Гэрээний үнийн дүнгийн <b>100</b> хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.</p> <p>Захиалагч нь гэрээнд заасан нөхцөл, хуваарийн дагуу төлбөрийг шилжүүлсэн тохиолдолд гүйцэтгэгч, нийлүүлэгч байгууллага нь НӨАТ-ыг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэх, баталгаажуулах үүрэг хүлээнэ.</p>   |
| <b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>1</sup></b>                  | <p>9.1. Алданги оногдуулах хувь: 0,5%</p> <p>Алдангийн нийт дүн: 5%</p>  |

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

**ЗАХИАЛАГЧ**

**НИЙЛҮҮЛЭГЧ**

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>3</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>2</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>3</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*